

Би дахин дахин Монголд ирэхийг мөрөөдөж байна

Буриад зоны наадам Улаанбаатар хотод дуулиантай болж өнгөрлөө. "Буриад хүний нэг өдөр", буриад дууны уралдаан болохын зэрэгцээ "Дагина" гоо бүсгүй шалгаруулах тэмцээн амжилттай болсон юм. Есөн гоо бүсгүй өрсөлдсөн эл тэмцээнд хоёрдугаар байранд шалгарсан Буриад Улсын гоо бүсгүй Арюна Бубееватай ярилцлаа.

Дөнгөж сая тэмцээн өндөрлөлөө. Сэтгэгдлээ хуваалцана уу?

Юуны өмнө Буриад зоны "Алтаргана-2010" наадмыг амжилттай зохион байгуулсан элэг нэгт монголчууддаа баярлалаа. "Алтаргана-2010" наадамд ярих зүйлээр баян сонирхолтой үйл явдал олон байлаа. Ялангуяа миний бие "Алтаргана-2010" наадмын хүрээнд болсон "Дагина" гоо бүсгүй шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсондоо баяртай байна. Тэр дундаа хоёрдугаар байр эзэлсэндээ сэтгэл хагалуун байна.

Тэргүүн байрын шагналыг атгаад алдлаа, харамсахгүй байна уу?

Хаанаас даа. Надад цаашид өөрийгөө сорих олон тэмцээн бий. Тэр бүхэнд бэлтгэлтэй оролцоход "Дагина" тэмцээн их зүйлийг хэлж өглөө. Өмнө нь нутагтаа болж байсан гоо бүсгүй шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай оролцож байсан. Одоо ч нутагтаа очоод тэмцээнд оролцоно.

Ингэхэд хэдэн настай билээ?

16 настай. Сая арван жилийн сургуулиа төгссөн. Тэмцээний явцад санаа их зовж байсан шүү.

Яагаад?

Би ямар харагдаж байгаа бол. Алхаа гишгээнээс гадна дуулах маань таалагдаж байгаа болов уу гээд л. Харин одоо тэмцээн өндөрлөж сэтгэл тайван байна.

Хамгийн ойрын зорилго юу вэ?

Цаашдаа загвараа орхихгүй ээ. Өөрийгөө улам дайчилж хөгжүүлнэ. Мөн сургуулиа төгсөөд дээд сургуульд орох гэж байна.

Ямар мэргэжил эзэмших гэж байна вэ?

Англи, хятад хэлд шамдан суралцана.

"Дагина" тэмцээнд оролцогчдоос хэн хамгийн хүчтэй өрсөлдөгч байв?

Бүгдээрээ хүчтэй өрсөлдөгчид байлаа. Гэхдээ би эхний гуравт шалгарна гэдэгтээ итгэлтэй байсан.

Түрүүлнэ гэж үнэхээр бодоогүй гэж үү?

Нууцгүй хэлэхэд сайн оролцоно гэж бодож байсан. Ер нь өөртөө итгэхгүй бол хэндээ итгэх вэ дээ.

"Дагина" тэмцээний зохион байгуулалтад хэд гэсэн дүн тавих вэ?

Төрөлх нутаг, ураг төрлөө магтсан мэндчилгээг оролцогчид дэвшүүлсэн. Мөн "Дагинын халтар" үндэсний бүжиг бүжиглэж, "Сэдьхэлэйм аялга" хэмээх орчин үеийн буриад дуу дуулж өрсөлдсөн. Гоёлын хувцас мөн л буриад үндэсний хэв маягийг харуулсан байлаа. Иймээс өв соёлоо дээдлэх, сурталчлахад үр дүнгээ өгсөн "Дагина" гоо бүсгүйн тэмцээний зохион байгуулалтад хувьдаа би онц дүн тавина. Тэмцээний явцад дүн удаан гарсан зэрэг бага зэргийн алдааг эс тооцвол тэмцээн хүмүүсийн сэтгэлд хүрсэн.


Загварын ертөнцийг яагаад сонгов?

Багаасаа загвар өмсөгч болно гэж боддог байлаа. Өндөр нуруутай болохоор хүн болгон намайг загвар өмсөгч болно гэдэг байсан л даа. Ер нь уйгагүй хөдөлмөрийн үр дүнд өнөөдрийн энэ шагнал надад ирсэн.

Монголд анх удаагаа ирж байна уу?

Өмнө нь ирж байсан. Монгол үнэхээр сайхан орон. Охидууд нь царайлгаас гадна байгалийн өнгө төрх ноёрхсон газар юм байна. Миний бие дахин дахин Монголд ирэхийг мөрөөдөж байна. Энэ дашрамд "Дагина" гоо бүсгүйн тэмцээнд өрсөлдсөн бүсгүйчүүд болон "TV 7 хоногийн хөтөч" сэтгүүлийн хамт олондоо илүү их амжилтыг хүсье.

Ярилцсан Д.Яруу



БУРИАДУУД БУЛТААР ЦУГЛАВ

Буриад ястнуудын хувьд хамгийн том баяр болох "Алтаргана" наадам ес дэх удаагаа боллоо. Төв цэнгэлдэх хүрээлэнд нээлтээ хийсэн энэ удаагийн "Алтаргана" наадам Улаанбаатар хотод болж байгаагаараа онцлог бөгөөд наадмыг БСШУЯ-наас зохион байгуулж байгаа. 1994 онд Хэнтий аймгийн Дадал сумын Засаг дарга Ц.Балдандоржийн санаачилгаар зохион байгуулсан Буриад дууны уралдаан нь "Алтаргана" наадмын эхлэл байжээ. Ганцхан сумын иргэдийн дунд зохион байгуулсан буриад дууны уралдаан өнөөдөр олон улсын наадам болон өргөжсөн нь монгол оронд амьдарч буй Буриад ястнуудын хамгийн том бахархал юм. Наадамд ОХУ-ын хэд хэдэн муж болон БНХАУ-ын Өвөр-Монголын өөртөө засах орон, манай улсын зарим аймгаас нийтдээ 15 мянга гаруй зочин, төлөөлөгч хүрэлцэн иржээ. Уг наадам нь хоёр жилд нэг удаа болдог уламжлалтай бөгөөд өмнөх наадмууд нь ОХУ-ын Буриад болон манай хөдөө аймгуудад болж байжээ. Дараагийн "Алтаргана" наадмыг Өвөрмонголын өөртөө засах оронд зохион байгуулахаар төлөвлөөд байгаа. Дэлхий дээр 600 мянга гаруй буриад ястан байдаг гэсэн тоо баримт бий. Тэдний төлөөлөл болохоор "Алтаргана" наадамд хүрэлцэн ирсэн нутаг нутгийн буриад ястнууд өөрсдийнхөө ахуйн соёлыг илэрхийлсэн хувцас хэрэглэлтэйгээ наадмын нээлтэд оролцлоо. Мөн нээлтийн үеэр урлаг соёлын олон арга хэмжээг зохион байгуулсан юм. Наадмын гол зорилго нь Буриадын үндэсний өв уламжлал, соёл, урлаг, спортын төрөл, зүйлийг өвлүүлэн уламжлуулах, шинэчлэн хөгжүүлэхэд оршиж байгаа юм.

